

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ.....	3
2.	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12	Шилэн дансны мэдээлэл	8
2.13	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3.	Менежментийн захидал	9
3.1	Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал	9
3.2	Зардлын данстай холбоотой асуудал	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2	Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4	Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/Өмчийн өөрчлөлтийн тайлан	12
4.5	Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	13

1. Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

САНГИЙН САЙД
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

2020.03.25 № 06/944
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Засгийн газрын нөөц сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Засгийн газрын нөөц сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Засгийн газрын нөөц сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kherig\Yawsan_Bichig\2020\0325SAG21.Docx


001051760

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Засгийн газрын нөөц сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн авлага үүсгэхгүй, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Засгийн газрын нөөц сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Засгийн газрын нөөц сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 05-наас 3 дугаар сарын 10-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Мөнхчимэг, Ч.Дашдаваа, гэрээт аудитор Ш.Ичинхорлоо нар хариуцаж хэрэгжүүлэв.

Засгийн газрын нөөц сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 11-2/405 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Засгийн газрын нөөц сангийн үйл ажиллагаа нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохион байгуулагдаж, тухайн жилийн төсөвт урьдчилан төлөвлөж тусгах боломжгүй дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулагдана. Үүнд:

- Гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах;
- Алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирсан хохирлыг арилгах;
- Төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардал;
- Засгийн газар олон улсын шүүх, арбитра хариуцагчаар татагдсан буюу тэдгээрээс гарсан шийдвэрийг биелүүлэхэд шаардагдах зардал;
- Олон улсын гэрээний дагуу Монгол Улс төлөх, тухайн жилийн төсөвт тусгагдаагүй татвар, төлбөр, хураамж;
- Байгууллага, иргэдээс тавьсан хүсэлт болон цаг үеийн шинжтэй зарим асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах зардал.
- Засгийн газрын нөөц сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд дээрх Засгийн газрын тусгай сангийн тухай хууль 2019 оны 11 дүгээр сарын 13-нд шинэчилсэн найруулга хийж 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр заасан байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Засгийн газрын нөөц сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “PTSan” программ хангамж ашигладаг байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Засгийн газрын нөөц сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгож 516.8 сая төгрөгөөр тооцсон.

2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Засгийн газрын нөөц сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт авлагын дүн өмнөх оноос 873.0 сая төгрөгөөр буюу 46.8 хувиар буурсан нь МИАТ ХК зээл төлсөн.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,862,7	989.7	-873.0
Нийт хөрөнгө	1,862,7	989.7	-873.0
Өр төлбөр	91.5	62.2	-29.3
Тайлант үеийн үр дүн	-	-843.7	843.7
Өмнөх үеийн үр дүн	1,771.2	1,771.2	0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,862.7	989.7	-873.0

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сангийн 2019 оны төсвийн урсгал санхүүжилт 25,000.0 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр бүрэн санхүүжигдсэн байна.

Засгийн газрын нөөц сангийн зарцуулалт 19,377.2 сая төгрөг буюу 77.5 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл тодорхойлж горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгө оруулалтын шинжтэй зардал дээр түүвэрлэн биет горим хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Засгийн газрын нөөц сангийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 12 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгүүдийг ашиглагч байгууллагад шилжүүлсэн эсэхэд тавих хяналт хангалтгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Нийт 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Засгийн газрын нөөц сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Засгийн газрын нөөц сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлагын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд МИАТ ТӨХК-иас авах алдангийн авлага 989.7 сая төгрөгийг дутуу барагдуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль эрх зүйн акт, хууль журам зөрчигдөх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийг мөрдөж, тайлант онд авлага үүсгэхгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Зарлагын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Засгийн газрын нөөц сангаас хөрөнгө оруулалтын зардлын төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн нь Засгийн газрын нөөц сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Төсвийн ерөнхийлөн захирагч энэ хуулийн 8.3-т заасан зориулалтаар өмнөх онд гарсан зардлын гүйцэтгэл, байгаль, цаг уурын болзошгүй өөрчлөлтийн талаарх судалгаа, урьдчилсан таамаглал, экспорт, импортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнийн хэлбэлзэл, цаашдын төлөв, төсвийн орлогын боломж, чадавхыг харгалзан тухайн жилд улсын

төсвөөс нөөц санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг төлөвлөнө”, 8 дугаар зүйлийн 8.3 “Тухайн жилийн төсөвт урьдчилан төлөвлөж тусгах боломжгүй дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд энэ хуулийн 8.1-д заасан сангийн хөрөнгийг зарцуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын нөөц сангийн тухай хуулийг мөрдөж ажиллах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,862,741,233.30	989,792,928.20
АВЛАГА	1,862,741,233.30	989,792,928.20
Бусад авлага	1,862,741,233.30	989,792,928.20
Байгууллагаас авах авлага	1,862,741,233.30	989,792,928.20
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,338,144,047.69	989,792,928.20
НИЙТ ӨР ТӨЛБӨР	91,571,850.00	62,210,000.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	91,571,850.00	62,210,000.00
Өглөг	91,571,850.00	62,210,000.00
Бараа үйлчилгээний зардлын өглөг	91,571,850.00	62,210,000.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,771,169,383.30	927,582,928.20
Засгийн газрын хувь оролцоо		
Хуримтлагдсан үр дүн	1,771,169,383.30	927,582,928.20
Өмнөх үеийн үр дүн	1,771,169,383.30	1,771,169,383.30
Тайлант үеийн үр дүн	-	(843,586,455.10)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,862,741,233.30	989,792,928.20

4.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	25,328,267,351.38	25,000,000,000.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	328,267,351.38	
Нийтлэг татварын бус орлого	328,267,351.38	
Төсөвт байгууллагын бус орлого	328,267,351.38	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
Торгууль төлбөрийн орлого	328,267,351.38	
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,000,000,000.00	25,000,000,000.00
Улсын төвлөрсөн төсвөөс	25,000,000,000.00	25,000,000,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	25,000,000,000.00	25,000,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	28,863,351,724.43	25,843,586,455.10
УРСГАЛ ЗАРДАЛ	28,863,351,724.43	19,439,472,020.29
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,968,109,708.66	19,439,472,020.29
Бараа үйлчилгээний бусад зардал	24,968,109,708.66	19,439,472,020.29
Бараа үйлчилгээний бусад зардал	24,968,109,708.66	19,439,472,020.29
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,895,242,015.77	6,404,114,434.81
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,895,242,015.77	6,404,114,434.81
Тогтворжуулалтын сан		5,622,737,979.71
Төвлөрүүлэх шилжүүлэг	3,895,242,015.77	781,376,455.10
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(3,535,084,373.05)	(843,586,455.10)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(3,535,084,373.05)	(843,586,455.10)

4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	30,224,023,059.77	27,172,589,354.70
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
Нийтлэг татварын бус орлого		
Төсөв байгууллагын өөрийн орлого	5,224,023,059.77	2,172,589,354.70
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
Бусад байгууллагаас	5,224,023,059.77	2,172,589,354.70
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,000,000,000.00	25,000,000,000.00
Улсын төвлөрсөн төсвөөс	25,000,000,000.00	25,000,000,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	25,000,000,000.00	25,000,000,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,244,023,059.77	27,172,589,354.70
УРСГАЛ ЗАРДАЛ	30,244,023,059.77	27,172,589,354.70
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,224,023,059.77	27,172,589,354.70
Бараа үйлчилгээний бусад зардал	26,096,425,521.38	20,676,903,069.89
Бараа үйлчилгээний бусад зардал	26,096,425,521.38	20,676,903,069.89
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,127,597,538.39	6,495,686,284.81
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,127,597,538.39	6,495,686,284.81
Тогтворжуулалтын сан	232,355,522.62	5,714,309,829.71
Төвлөрүүлэх шилжүүлэг	3,895,242,015.77	781,376,455.10
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл			5,306,253,756.35	5,306,253,756.35
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			(3,535,084,373.05)	(3,535,084,373.05)
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл			1,771,169,383.30	1,771,169,383.30
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			(843,586,455.10)	(843,586,455.10)
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл			927,582,928.20	927,582,928.20

4.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,000,000,000.00	25,000,000,000.00	-	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	25,000,000,000.00	25,000,000,000.00	-	100.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,000,000,000.00	25,000,000,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	25,000,000,000.00	25,000,000,000.00	-	100.0
Тогтворжуулалтын сан		5,622,737,979.71	(5,622,737,979.71)	
Бараа үйлчилгээний бусад зардал	25,000,000,000.00	19,377,262,020.29	5,622,737,979.71	77.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25,000,000,000.00	25,000,000,000.00	-	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	25,000,000,000.00	25,000,000,000.00	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	25,000,000,000.00	25,000,000,000.00	-	100.0

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.03.25	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2020/10/СТА-ЗГНС
Шалгагдсан байгууллагын нэр:	Засгийн газрын нөөц сангийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит			Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд МИАТ ТӨХК-иас авах алдангийн авлага 989.7 сая төгрөгийг дутуу барагдуулсан.	-	Зөвлөмж өгөх	Төрийн сангийн газрын дарга	М.Батхуяг
2	Засгийн газрын нөөц сангаас хөрөнгө оруулалтын зардлын төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн.	-	Зөвлөмж өгөх	Төрийн сангийн газрын дарга	М.Батхуяг
	Нийт дүн	-			

[illegible]

[illegible]